

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2021/02/СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймгийн Сайншанд сум 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 7052-2734 Цахим хаяг: Gan-ulzii.t@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 7052-3020 Цахим хаяг: Oyuntulkhuur.u@audit.gov.mn Ахлах аудитор: Ч.Ариунаа Утас: 7052-3020 Цахим хаяг: Ariunaa.ch@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ХХҮГ	Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газар

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3-4
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1.Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2.Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3.Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4.Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5.Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8-10
3.Аудитын тайлан	11
3.1.Ерөнхий зүйл	11
3.2.Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	11
3.3.Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	11
3.4.Материаллаг байдал	12
3.5.Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	12
3.6.Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	13-14
3.7.Шилэн дансны мэдээлэл	14
3.8.Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.9.Аудитын илрүүлэлт	15
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	15
Аудитын зөвлөмж	15
3.10.Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	15
4.Менежментийн захидал	16
5.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	17

Аудитын гэрчилгээ



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021.02.25 № 1-6/265
танай _____ -ны № _____ -т

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГА Д.ЦЭНДМАА ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Т.ГАН-ӨЛЗИЙ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,188,061,452.00</u>	<u>1,169,809,739.00</u>
33	АВЛАГА	1,188,061,452.00	1,168,650,739.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	37,873,700.00	15,442,608.00
335	Бусад авлага	1,150,187,752.00	1,153,208,131.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,150,187,752.00	1,153,208,131.00
34	УРЬДЧИЛГАА	-	1,159,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	1,159,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,188,061,452.00</u>	<u>1,169,809,739.00</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>5,389,821.00</u>	<u>96,928,021.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,389,821.00	96,928,021.00
413	Өглөг	5,389,821.00	96,928,021.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	967,921.00	2,947,821.00
4136	Бусад өглөг	4,421,900.00	93,980,200.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	4,421,900.00	93,980,200.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,182,671,631.00</u>	<u>1,072,881,718.00</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,182,671,631.00	1,072,881,718.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,182,671,631.00	1,072,881,718.00
51210	Өмнөх үеийн үр дүн	914,459,538.00	1,182,671,631.00
51220	Тайлант үеийн үр дүн	268,212,093.00	(109,789,913.00)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,188,061,452.00</u>	<u>1,169,809,739.00</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	810,470,950.00	571,331,618.22
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,470,950.00	148,734,618.22
120	Нийтлэг татварын бус орлого	16,470,950.00	148,734,618.22
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16,470,950.00	148,734,618.22
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,470,950.00	148,734,618.22
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	794,000,000.00	422,597,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	794,000,000.00	257,181,000.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	794,000,000.00	257,181,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	165,416,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	4,416,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	161,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	542,258,857.00	681,121,531.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	542,258,857.00	681,121,531.22

Дорноговь аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,900,000.00	8,976,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,900,000.00	3,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,900,000.00	3,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,976,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	5,976,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	538,358,857.00	672,145,531.22
2132	Бусад урсгал шилжүүлэг	193,324,235.00	224,399,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	193,324,235.00	224,399,200.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,470,950.00	143,207,510.22
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,470,950.00	143,207,510.22
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	117,208,051.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	117,208,051.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	211,355,621.00	304,538,821.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	211,355,621.00	304,538,821.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>268,212,093.00</u>	<u>(109,789,913.00)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>268,212,093.00</u>	<u>(109,789,913.00)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,159,132,557.00</u>	<u>844,291,239.22</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	265,700,271.00	421,694,239.22
120	Нийтлэг татварын бус орлого	265,700,271.00	421,694,239.22
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	265,700,271.00	421,694,239.22
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	249,229,321.00	272,959,621.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,470,950.00	148,734,618.22
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	893,432,286.00	422,597,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	893,432,286.00	257,181,000.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	794,000,000.00	257,181,000.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	99,432,286.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	165,416,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	4,416,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	161,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,159,132,557.00</u>	<u>844,291,239.22</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,159,132,557.00	844,291,239.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,900,000.00	8,976,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,900,000.00	3,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,900,000.00	3,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,976,000.00

Дорноговь аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	5,976,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,155,232,557.00	835,315,239.22
2132	Бусад урсгал шилжүүлэг	772,324,235.00	410,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	772,324,235.00	410,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,470,950.00	148,734,618.22
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,470,950.00	148,734,618.22
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	117,208,051.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	117,208,051.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	249,229,321.00	276,580,621.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	249,229,321.00	276,580,621.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	1,182,671,631.00	1,182,671,631.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	1,182,671,631.00	1,182,671,631.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн				0.00
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	1,182,671,631.00	1,182,671,631.00
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	1,182,671,631.00	1,182,671,631.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	1,182,671,631.00	1,182,671,631.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-109,789,913.00	-109,789,913.00
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	1,072,881,718.00	1,072,881,718.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хөтөлбөр, төслийн ангилал		Төлөвлөгөө		Гүйцэтгэл		ЗӨРҮҮ	Хөрөнгө
Код	Үзүүлэлт	Хүний тоо	Хөрөнгө	Хүний тоо	Хөрөнгө	Хүний тоо	
11	ОРЛОГЫН НИЙТ ДҮН	1,137	550,654,600	261	844,291,239.22	876	(293,636,639.22)
112	ХЭД сангаас хуваарилсан санхүүжилт	1,031	531,557,600	-	412,000,000.00	1,031	119,557,600.00
113	Гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламж	106	10,597,000	-	10,597,000.00	106	-
115	ХБИ ажиллуулаагүйн төлбөрийн орлого	-	8,500,000	-	148,734,618.22	-	(140,234,618.22)
118	Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт	-	-	261	272,959,621.00	(261)	(272,959,621.00)
120	Нэр данс зөрүү орлого	-	-	-	37,983,581.00	-	(37,983,581.00)
121	Бусад	-	-	-	(37,983,581.00)	-	37,983,581.00
2	ЗАРЦУУЛАЛТЫН ДҮН	1,139	542,154,600	2,461	844,291,239.22	(1,322)	(302,136,639.22)
21	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээ хангах үйлчилгээ	-	3,249,000	870	839,750.00	(870)	2,409,250.00
211	Ганцаарчилсан	-	3,249,000	820	322,750.00	(820)	2,926,250.00
2111	Ажил мэргэжлээ сонгох, үйлчилгээ авах тухай зөвлөгөө өгөх /ганцаарчилсан/	-	-	406	164,000.00	(406)	(164,000.00)
2113	Ажил хайх, чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх /ганцаарчилсан/	-	3,249,000	414	158,750.00	(414)	3,090,250.00
212	Бүлгээр	-	-	50	517,000.00	(50)	(517,000.00)
2122	ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох /бүлгээр/	-	-	-	23,050.00	-	(23,050.00)
2123	Ажил хайх, чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх /бүлгээр/	-	-	50	493,950.00	(50)	(493,950.00)
22	Ажилд зуучлах үйлчилгээ	592	4,141,000	1,124	3,070,250.00	(532)	1,070,750.00
222	Ажилд зуучлах үйлчилгээ	592	4,141,000	1,124	3,070,250.00	(532)	1,070,750.00
23	Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр	8	1,920,000	12	1,920,000.00	(4)	-
232	Хөдөлмөр эрхлэлтийн сургалтанд хамруулах	8	1,920,000	12	1,920,000.00	(4)	-
2322	Мэргэжлийн болон давтан явуулын сургалт	8	1,920,000	12	1,920,000.00	(4)	-
24	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	323	219,750,000	262	171,846,000.00	61	47,904,000.00
241	Санхүүгийн дэмжлэг /100 хувь эргэн төлөгдөх/	24	118,000,000	19	93,000,000.00	5	25,000,000.00
242	Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалт явуулах	35	1,050,000	25	750,000.00	10	300,000.00
2424	Аж ахуй эрхлэх төсөл, төлөвлөгөө боловсруулах	35	1,050,000	25	750,000.00	10	300,000.00
244	Ажлын байрны түрээсийн хөнгөлөлт	-	6,200,000	-	-	-	6,200,000.00
245	Ажил олгогчийг дэмжих арга хэмжээ	3	16,860,000	4	16,860,000.00	(1)	-
2460	Нийтийг хамарсан ажил	242	67,760,000	195	51,356,000.00	47	16,404,000.00
248	Бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний	19	9,880,000	19	9,880,000.00	-	-

Дорноговь аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	ногоо тариалах						
25	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	52	109,265,200	42	71,684,200.00	10	37,581,000.00
250	Гарааны бизнесийг хөгжүүлэх арга хэмжээ зохион байгуулах	2	15,000,000	2	10,000,000.00	-	5,000,000.00
252	Санхүүгийн дэмжлэг /100 хувь эргэн төлөгдөх/	9	90,000,000	6	60,000,000.00	3	30,000,000.00
253	Ажлын байрны түрээсийн хөнгөлөлт	-	889,200	1	694,200.00	(1)	195,000.00
254	Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалт	41	1,215,000	33	990,000.00	8	225,000.00
255	Борлуулалтын дэмжлэг	-	2,161,000	-	-	-	2,161,000.00
26	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	16	75,088,800	16	66,786,400.00	-	8,302,400.00
261	Малчин өрхийг малжуулах /100 хувь эргэн төлөгдөх/	15	73,980,000	14	65,980,000.00	1	8,000,000.00
263	Гэрээт малчин өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ	1	1,108,800	2	806,400.00	(1)	302,400.00
27	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	29	57,650,000	32	56,650,000.00	(3)	1,000,000.00
271	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжих арга хэмжээ	28	53,410,000	31	52,410,000.00	(3)	1,000,000.00
2712	Санхүүгийн дэмжлэг /100 хувь эргэн төлөгдөх/	10	50,000,000	10	50,000,000.00	-	-
2714	Ажлын байрны түрээсийн хөнгөлөлт	-	1,000,000	-	-	-	1,000,000.00
2715	Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалт	11	330,000	11	330,000.00	-	-
2716	Хөдөлмөр эрхлэлтийн сургалт	7	2,080,000	10	2,080,000.00	(3)	-
272	Ажил олгогчийг дэмжих арга хэмжээ	1	4,240,000	1	4,240,000.00	-	-
2721	Ажил олгогчийн урамшуулал	1	4,240,000	1	4,240,000.00	-	-
28	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	12	27,356,500	9	24,000,000.00	3	3,356,500.00
281	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	4	3,356,500	-	-	4	3,356,500.00
282	Санхүүгийн дэмжлэг /100 хувь эргэн төлөгдөх/	8	24,000,000	9	24,000,000.00	(1)	-
32	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл	-	3,032,100	-	2,000,000.00	-	1,032,100.00
321	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл	-	3,032,100	-	2,000,000.00	-	1,032,100.00
34	Бүртгэл мэдээллийн сүлжээ ажиллуулах	-	8,180,000	-	940,000.00	-	7,240,000.00
342	Програм хангамж, техник хангамжийн шинэчлэлт	-	8,180,000	-	940,000.00	-	7,240,000.00
35	Хөдөлмөрийн салбарын ажилтнууд, ХНЗ-ийн 3-н талт хорооны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хийгдэх чадавч бэхжүүлэх сургалт	-	5,535,000	-	5,535,000.00	-	-
352	Сум хороодын ажилтнуудын сургалт	-	5,535,000	-	5,535,000.00	-	-
37	Хөтөлбөр төслийн хяналт үнэлгээ	-	6,000,000	-	4,768,400.00	-	1,231,600.00
373	Хөтөлбөр төслийн хяналт үнэлгээ	-	6,000,000	-	4,768,400.00	-	1,231,600.00
39	Гарын авлага хэвлэмэл материал	-	8,150,000	-	-	-	8,150,000.00
391	Гарын авлага хэвлэмэл материал хэвлэх, олшруулах	-	8,150,000	-	-	-	8,150,000.00
40	Засгийн газар, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл,	-	-	1	1,960,000.00	(1)	(1,960,000.00)

Дорноговь аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	бусад шийдвэрээр тодорхойлсон хөтөлбөр төслийн санхүүжилт						
405	Хүүхэд хамгаалагч төсөл	1	2,240,000	1	1,960,000.00	-	280,000.00
50	Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр	106	10,597,000	93	6,976,000.00	13	3,621,000.00
502	Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих санхүүгийн бус дэмжлэг	106	10,597,000	93	6,976,000.00	13	3,621,000.00
50201	Зээлийн өмнөх сургалт	76	912,000	69	828,000.00	7	84,000.00
50202	Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээ	30	7,185,000	24	5,148,000.00	6	2,037,000.00
50204	Бичил бизнес эрхлэгчдэд мэдээлэл зээл, санхүүгийн бус үйлчилгээний талаар мэдээлэл түгээх	-	1,000,000	-	1,000,000.00	-	-
50205	Бичил бизнес эрхлэгчдийн дэмжих арга хэмжээний хяналт, үнэлгээ	-	1,500,000	-	-	-	1,500,000.00
61	Төвлөрүүдэлт	-	-	-	425,315,239.22	-	(425,315,239.22)
6110	Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт - Төв сан	-	-	-	263,044,121.00	-	(263,044,121.00)
6112	Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт - Сангийн яам	-	-	-	9,915,500.00	-	(9,915,500.00)
6120	ХБИ ажиллаагүй төлбөрийн орлого - Төв сан	-	-	-	143,207,510.22	-	(143,207,510.22)
6122	ХБИ ажиллаагүй төлбөрийн орлого - Сангийн яам	-	-	-	5,527,108.00	-	(5,527,108.00)
6130	Санхүүжилтын буцаалт - Төв сан	-	-	-	3,621,000.00	-	(3,621,000.00)
9	Эцсийн үлдэгдэл	-	-	-	-	-	-
91	Харилцахын эцсийн үлдэгдэл	-	-	-	-	-	-
92	Кассын эцсийн үлдэгдэл	-	-	-	-	-	-

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Д.Цэндмаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд үйлчлүүлэгчийн батлагдсан төсөв гүйцэтгэлтэй холбоотой зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021.02.22-оос 2021.02.25–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021.02.25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, ахлах аудитор Ч.Ариунаа хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг **Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт** 2021.01.25-ны өдрийн 48 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ:

- Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр баталсан удирдамжийн дагуу 2019 онд хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн баримт бичигт дотоод хяналт шалгалт хийгдсэн байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны нийт зардлын дүн 353,215.6 мянган төгрөгийн 1 хувиар буюу 3,532.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчиллөө.

Аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны нийт хөрөнгө 1,169,809.7 мянган төгрөгийн 1 хувиар буюу 11,698.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 18,251.7 мянган төгрөгөөр буюу 1.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, өглөгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	1,188,061.4	1,168,650.7	19,410.7
Урьдчилж гарсан зардал		1,159.0	1,159.0
Нийт хөрөнгө	1,188,061.4	1,169,809.7	18,251.7
Өр төлбөр	5,389.8	96,928.0	91,538.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,182,671.6	1,072,881.7	-109,789.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,188,061.4	1,169,809.7	18,251.7

Авлага дансны үлдэгдэл өссөн нь 100 хувийн эргэн төлөгдөх нөхцөлтэй хувиараа хөдөлмөр эрхлэгч нөхөрлөл, хоршоо, байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөрт тайлант онд шинээр 93,000.0 мянган төгрөг, ХБИ-ний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт шинээр 25,000.0 мянган төгрөг, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт шинээр 73,980.0 мянган төгрөг, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрт 24,000.0 мянган төгрөг, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 60,000.0 мянган төгрөг олгосноос шалтгаалжээ. Мөн татаас санхүүжилтийн авлага 15,442.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Авлага дансны үлдэгдэлд хугацаа хэтэрсэн 186,358.2 мянган төгрөгийн авлага байна.

Өр төлбөр дансны үлдэгдэлд 91,538.2 мянган төгрөгөөр өссөн нь 119,557.6 мянган төгрөгийн санхүүжилт дутуу авснаас хэрэгжүүлсэн хөтөлбөртэй холбоотой өглөг үүссэн байна. Үүнд: Залуучуулын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр 25,225.0 мянган төгрөгийн, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр 8,302.4 мянган төгрөг, ахмад мэргэжилтний зөвлөх

үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн 3,115.0 мянган төгрөг, ажилд зуучлах үйлчилгээ 835.0 мянган төгрөг, хүүхэд хамгаалагч төслийн 280.0 мянган төгрөг, хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэхэд 6,500.0 мянган төгрөг, төслийн зээл авсан иргэдийн түрээсийн хөнгөлөлт 5,491.8 мянган төгрөг, хөдөлмөрийн зах зээлийн судалгааны 5,085.0 мянган төгрөг, ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн 36,704.0 мянган төгрөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,072,881.7 мянган төгрөг болж 109,789.9 төгрөгөөр буурахад тайлант оны үр дүн нөлөөлжээ.

ХЭДС-ийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 239,139.3 мянган төгрөгөөр буурч, 571,331.6 мянган төгрөг байна.

Нийт зардал өмнөх оноос 138,862.7 мянган төгрөгөөр буюу 25 хувиар өссөн байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд орлогын төлөвлөгөөг 441,000.0 мянган төгрөгөөр, зардлыг 1,633,500.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс орлогыг 129,057.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, зарлагыг 1,101,942.4 мянган төгрөгөөр бууруулан баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөрийн 23 арга хэмжээг санхүүжүүлэхээр 550,654.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 531,557.6 мянган төгрөгийг ХЭДС-аас, Дэлхийн банкны төслөөс 10,597.0 мянган төгрөг, 8,500.0 мянган төгрөгийг ХБИ ажиллуулаагүйн төлбөрийн орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр ХЭДС-аас 412,000.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, дэлхийн банкны төслөөр 10,597.0 мянган төгрөг, ХБИ ажиллуулаагүйн төлбөрийн орлогоос 148,734.6 мянган төгрөг, нийт 560,734.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 412,000.0 мянган төгрөгийг зарцуулж, 148,734.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Мөн санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтөөс 272,959.6 мянган төгрөг төвлөрснийг ХЭДС-д буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 412,000.0 мянган төгрөг буюу 77.5 хувьтай байгаа нь ХЭДС-аас 119.5 мянган төгрөгийн санхүүжилт дутуу олгосонтой холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Дорноговь аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн тайлант онд 8,500.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 148,734.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, 140,234.6 мянган төгрөгөөр давсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
ХБИргэн ажиллуулаагүйн орлого	8,500.0	148,734.6	140,234.6	
Нийт дүн	8,500.0	148,734.6	140,234.6	

Зээлийн эргэн төлөлтийн орлого 272,959.6 мянган төгрөг байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 5 хөтөлбөрт зориулан 531,557.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 531,557.6 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 531,557.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 8,500.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлыг санхүүжүүлсэн орлогын гүйцэтгэлийг авч үзвэл ХБИ ажиллуулаагүйн орлогоос 148,734.6 мянган төгрөг төвлөрсөн байна.

Урсгал зардлын гүйцэтгэл 412,000.0 мянган төгрөг буюу 77.5 хувьтай байгаа нь 119,557.6 мянган төгрөгийн санхүүжилт дутуу авсантай холбоотой байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус дансанд 165,416.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн бөгөөд үүний 161,000.0 мянган төгрөгийн ХХҮЕГ-аас олгосон санхүүжилт, 4,416.0 мянган төгрөг нь Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй туршилтын хөтөлбөрийн санхүүжилт байна. Үүнээс 162,000.0 мянган төгрөгийг зарцуулж, 3,416.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 144 мэдээллээс 130 мэдээллийг хугацаанд нь, 14 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 5 зөвлөмж өгч бүрэн хэрэгжсэн байна. Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	5	-	5	-	-		
Нийт дүн	5		5		-		

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар өмнөх зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, орлогын төлөвлөгөөг бодитой төлөвлөөгүй зөрчил илэрсэн бөгөөд зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлээ

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

1. Тайлант онд ХБИ ажиллуулаагүйн төлбөрийн орлого 8500.0 мянган төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөж батлуулсан бөгөөд гүйцэтгэлээр 148734.6 мянган төгрөг төвлөрсөн байна. Орлогын төлөвлөгөөг бодитой төлөвлөх талаар өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Энэ нь үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 91,144.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

4.1.1 Илрүүлэлт

Тайлант оны төсөвт 4 удаагийн тодотгол хийгдэж, батлагдсан төсвөөс 119,557.9 мянган төгрөгийн санхүүжилт дутуу авч 91,144.2 мянган төгрөгийн хөтөлбөрийн өглөг үүссэн байна.

4.1.2 Эрсдэл

Энэ нь үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалт тус тус зөрчсөн байна.

4.1.3 Зөвлөмж

Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах, үүссэн өр төлбөрийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор барагдуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021	Аудитын нэр: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: ДГА-2021/02/СТА- ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант онд ХБИ ажиллуулагүйн төлбөрийн орлого 8500.0 мянган төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөж батлуулсан бөгөөд гүйцэтгэлээр 148734.6 мянган төгрөг төвлөрсөн байна. Орлогын төлөвлөгөөг бодитой төлөвлөх талаар өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	-	Албан шаардлага өгөх	Дарга Нягтлан бодогч	Д.Цэндмаа Т.Азаяа
2	Тайлант оны төсөвт 4 удаагийн тодотгол хийгдэж, батлагдсан төсвөөс 119,557.9 мянган төгрөгийн санхүүжилт дутуу авч 91,144.2 мянган төгрөгийн хөтөлбөрийн өглөг үүссэн байна.	91,442.2	Зөвлөмж өгөх	Дарга Нягтлан бодогч	Д.Цэндмаа Т.Азаяа
ДҮН		91,442.2			